МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД, ТЭДГЭЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

(Мэдээлэл лавлагаа)

Ц.Норовдондог, Ц.Болормаа, Д.Живгаагүнсэл,
Ө.Мөнхтунгалаг, Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

Нэг. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа судалгаа, шинжилгээний байгууллагууд, тэдгээрийн мэдээллийн санг УИХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах боломжийн талаарх санал, дүгнэлт

Хоёр. Хавсралт судалгаанууд
1. “Мэдээллийн нэгдсэн сан байгуулах тухай” Засгийн газрын 214 дүгээр тогтоол, 2013 он.
2. “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 187 дугаар тушаал, 2007 он.
3. Шинжлэх ухаан технологийн сан, Шинжлэх ухааны академийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл
4. Төрийн байгууллагуудын судалгааны мэдээллийн сан
5. Судалгаа, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын мэдээллийн сан
6. Их, дээд сургуулиудын судалгааны мэдээллийн сан

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД, ТЭДГЭЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ УИХ-ЫН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ БОЛОМЖИЙН ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгын дагуу судалгаа шинжилгээнд суурилсан ухаалаг төрийн тогтолцоог бий болгох зорилт хэрэгжиж эхлээд байна. Төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага болохын хувьд УИХ-ын хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ, мэдээлэл лавлагааны эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байна.

Хууль тогтоох байгууллагын судалгаа, мэдээллийн эрэлт хэрэгцээг уян хатан, шуурхай хангах боломжийг бүрдүүлэхийн тулд УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээний хэлтсээс Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус судалгаа, шинжилгээний байгууллага, нэгжүүд, тэдгээрийн бий болгож байгаа оюуны бүтээлийн сан, судалгааны мэдээллийн санг төвлөрүүлэн төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах боломжийн талаар судалгаа хийж, нөхцөл байдлыг тодрууллаа.

Судалгаанаас үзэхэд, Монгол улсын хэмжээнд харьцангуй тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 100 гаруй судалгаа, шинжилгээний байгууллага, нэгжүүд байна. Үүнээс:
1. Төрийн байгууллагын бүтэц, харьяанд ажилладаг судалгаа шинжилгээ, мониторинг үнэлгээний нэгж, хүрээлэн - 35
2. Төрийн бус статустай бодлого судлалын хүрээлэн-9
3. Шинжлэх ухааны төв байгууллага -1
4. ШУ-ын салбарын төрөлжсөн академи-2
5. ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн-21,
6. Төрийн өмчит их дээд, сургуулиудын харьяа судалгааны төв, хүрээлэн -27

7. Шинжлэх ухаан, технологийн сан-1
8. Шинжлэх Ухааны академийн мэдээллийн нэгдсэн сан-1
9. Судалгааны сан бүхий Номын сан-

Эдгээр эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын хүчин чадал, судалгааны бүтээлийн санг төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, хэрэглээг бий болгох шаардлагатай байна.

Улсын хэмжээнд бүрдэж буй судалгааны мэдээллийн сангийн байдлыг тоймлон авч үзвэл:

а/ Шинжлэх ухааны судалгааны тухайд: ШУА-ын харьяа эрдэм шинжилгээний 21 хүрээлэн, 2 академи нь ЗГ-ын ШУТС-ийн захиалгаар, төсвийн санхүүжилтээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж байна. ШУА-ийн мэдээллийн нэгдсэн санд 1975 оноос хойш улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 3600 гаруй судалгаа боловсруулалтын ажлын тайлан, 4800 орчим диссертаци, автореферат, 4300 гаруй эрдэмтдийн нэгдсэн бүртгэл мэдээлэл, оновчтой саналын гэрчилгээ авсан бүтээл хадгалагдаж байна. 2013.04.04-ны өдрийн байдлаар Монгол Улсын оюуны санд 31396 бүтээлийг бүртгэснээс, судалгаа боловсруулалтын ажил 3608, үүнээс тайлан - 2703, төсөл - 905, оновчтой санал 18660, эрдэмтэн санд эрдэмтдийн бүтээл, диссертаци 2711, 4314 эрдэмтдийн мэдээлэл бүртгэлтэй байгаа ба дээрх мэдээллүүдийг байгаль, техник, анагаах, ХАА, нийгэм, хүмүүнлэг гэсэн шинжлэх ухааны 5 салбараар төрөлжүүлэн дижитал хэлбэрээр Оюуны санд хадгалдаг гэсэн байна. Одоогийн байдлаар Шинжлэх ухаан технологийн санд Шинжлэх ухааны мэдээллийн нэгдсэн сан төвлөрч байна.

б/ Академик судалгааны тухайд: Төрийн өмчит 7 их дээд, сургууль, харьяа 13 сургуулийн дэргэд нийт 25 судалгааны төв, хүрээлэн ажиллаж байна. Их, дээд сургуулиудын судалгааны төв, хүрээлэнгүүд нь одоогоор ШУТС болон нийтэд зарлагдсан судалгааны ажлыг захиалгаар гүйцэтгэж байна. Мөн БСШУЯ-ны сайдын 2007оны 187-р тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”-ын дагуу судлаачид магистрын ажил, диссертацийг сургуулийн номын сангийн эрдэм шинжилгээний фондод хүлээлгэн өгөх журамтай. Мөн энэхүү журмын дагуу судлаачид бүтээлээ Үндэсний Номын сан, мэдээллийн технологийн үндэсний парк, түшиглэсэн болон суралцсан сургуулийнхаа номын санд хүлээлгэн өгөх үүрэгтэй боловч одоогоор албан ёсоор хүлээлгэн өгдөг практик ховор байна. Их, дээд сургуулиудын хувьд сургуулийнхаа цахим сайтад зөвхөн судалгааны ажлын жагсаалтаа оруулдаг ба судалгааны тайланг тэр бүр бүрэн эхээр нь байршуулдаггүй байна.

в/ Бодлогын судалгааны тухайд: Монгол Улсад бодлого судлалын салбар одоогоор системтэй хөгжиж чадаагүй байна. Ерөнхийлөгч, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, УИХ, Засгийн газар, ЗГ-ын харьяа яам, агентлагууд өөр өөрсдийн онцлогт тохирсон, шуурхай ажиллах чадвартай, өндөр түвшинд мэргэшсэн бодлого судлалын институтийг тогтвортой ажиллуулж чадаагүй, байсан ч дорвитой ажиллах боломж тааруу байгаа дүр зураг харагдаж байна. Судалгаанаас үзэхэд, Ерөнхийлөгчийн харьяанд-2 хүрээлэн, УИХ-ын Тамгын газарт Судалгаа шинжилгээний нэгж-1, УИХ-ын харьяа байгууллагуудын бүтцэд судалгааны нэгж-4, Ерөнхий сайдын харьяа-1, Шадар сайдын харьяа-4, Засгийн газрын харьяа-1, яамдын бүтцэд- 8, агентлагийн бүтцэд-14 судалгааны нэгж, байгууллага байна.

Одоогийн байдлаар, Засгийн газрын 2013.06.15-ны өдрийн 214-р тогтоолоор “ Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, зохицуулах журам”-ыг баталсан байна. Уг журмаар яам, агентлаг, орон нутгийн байгууллагууд, шинжлэх ухааны академи, судалгааны хүрээлэнгүүд, төрийн өмчит их дээд сургуулиуд, төрийн өмчит компаниуд хавсралтаар баталсан статистик мэдээлэл, бодлогын судалгаа, ТЭЗҮ, ААН-ийн тодорхой

мэдээллүүдээ Эдийн засгийн хөгжлийн яаманд ирүүлж байх үүрэгтэй. ЭЗХЯ хариуцаж эдгээр байгууллагуудаас мэдээлэл гаргуулан авч, Засгийн газрын мэдээллийн цахим санг бүрдүүлэхээр уг журамд тусгажээ.

г/ УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн тухайд: Төрийн байгууллагуудын судалгаа, хяналт, үнэлгээний чиг үүрэг бүхий нэгжүүдийн үйл ажиллагаа сул байгаа учраас хэрэгцээтэй мэдээллээ богино хугацаанд гаргуулан авч чадахгүй байх, дүрэм журмаар тогтоосон хүнд сурталтай тулгарах явдал УИХ-ын Тамгын газрын судлаачдад тулгарч байна.

Парламентад үйлчилгээ үзүүлдэг судалгааны албаны үйл ажиллагаа нь өөрийн гэсэн онцлогтой бөгөөд үйл ажиллагаа нь уян хатан, шуурхай, улс төрөөс ангид, хараат бус, төвийг сахисан зарчимд нийцсэн байх шаардлагатай. Гэвч тус хэлтэс нь нэг талаас, аль болох хурдан шуурхай ажиллах, мэдээллийн олон талт эх үүсвэрийг судалгаанд ашиглах, хамгийн оновчтой бодлогын шийдлийг тодорхойлох, мэдээлэл лавлагааг системтэй, бүрэн гүйцэд гаргаж өгөхийг УИХ-ын гишүүд шаарддаг бол, нөгөө талаас мэдээллийн хомсдолтой байнга нүүр тулж байна. Тамгын газарт 2013 онд бүтцийн өөрчлөлт хийхдээ Судалгаа шинжилгээний хэлтсийн орон тоог 50% цөөлж, бодлогын судалгааг бусад байгууллага, судлаачдаар гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн боловч өнгөрсөн хугацаанд нэг ч судалгааг гадны байгууллагаар хийлгээгүй. Гишүүдийн судалгаа, мэдээллийн эрэлт хэрэгцээ өсөж байгаа бөгөөд судалгааны захиалга, судлаачийн ажлын ачаалал өмнөх жилүүдээс эрс нэмэгдсэн. Тендер зарлаж судалгааны ажлыг бусад байгууллага, судлаачдаар гүйцэтгүүлэх нь УИХ-ын үйл ажиллагааны онцлогоос үүдэн төдийлөн оновчтой биш болох нь харагддаг. Цаг хугацааны хувьд судалгааны ажил нь парламентын хэлэлцүүлгийн шатанд л чухал болохоос хууль батлагдсаны дараагаар цаг хугацааны хувьд ач холбогдлоо алддаг. Судалгааны агуулга, зорилгын хувьд аль ч орны парламентын гишүүд толгой эргэм тооцоотой, шинжлэх ухааны хэллэгтэй судалгааны ажлыг уншдаггүй бөгөөд тэдэнд зориулж судалгааны тайланг хялбаршуулах, аналитик мэдээлэл болгон бэлтгэж өгөх нь Парламентын судалгааны албаны үүрэг байдаг.

Аливаа улс орон төрийн бодлогын дархлаа тогтоох, хар хайрцагны бодлогоо алдахгүй байхын тулд бодлогын асуудлаар гадны байгууллага, судлаачдад тэр болгон итгэл үзүүлдэггүй. Судалгааны бүх салбарыг жигд хөгжүүлж, төр зөвхөн олон талт мэдээллийн эх сурвалжуудын хэрэглэгч нь болдог. Хэрэглээг бий болгох итгэмжлэгдсэн албаа нь парламентын судалгааны албаа байх бөгөөд парламентын судалгааны албаны үйл ажиллагааны процедур, судалгааны арга зүй, тайлан бичлэгийн хэв маяг, ёс зүйн дүрмүүд бий болж бодлогын судалгааны бүтээгдэхүүн, үйлчилгээний цогц салбар болон хөгжиж байна. Энэ талаар УИХ-ын Судалгааны төв нь АНУ-ын Конгрессийн Судалгааны албa, БНСУ-ын Үндэсний Ассамблейн Судалгааны албанаас мэргэжил, арга зүйн туслалцаа, зөвлөх үйлчилгээ авсан бөгөөд стандартыг баримтлан ажиллахын төлөө чармайж байгаа юм.

Бусад орнуудын Парламент болон Засгийн газар нь албан ёсны итгэмжлэгдсэн бодлогын судалгаа, шинжилгээний албатай, улсын хэмжээнд бий болж байгаа оюуны санг төвлөрүүлэх эрхтэй, өндөр түвшний мэргэшсэн судлаач, шинжээчидтэй болж өргөжсөөр байна. Гэвч манайд ийм тогтолцоо бүрдээгүйн улмаас ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс, гадны санхүүжилттэй байгууллагууд бодлогын судалгаа хийх, УИХ, ЗГ-т хандан зөвлөмж гаргах, өөрсдийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргуулах, лобби ажиллагаа явуулах байдал ажиглагдаж байна.

Эдгээр нөхцөл байдлаас сэргийлж дэлхийн ихэнх орнууд парламентын судалгааны албаа төрийн албаны статустай, мэргэшсэн албa болгон өөрийн харьяанд ажиллуулж, улс төрийн дарамт шахалтаас ангид, хараат бусаар ажиллах нөхцөл болон эрх зүйн орчныг бүрдүүлэх, чадавхыг нь сайжруулахад байнга анхаарч байдаг.

УИХ-ын хувьд ядаж одоо байгаа боломжоо бүрэн ашиглах, үүний тулд төрийн байгууллагуудын албан ёсны мэдээлэлд тулгуурласан статистик дата сан бүрдүүлэх, судалгааны олон талт эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлж хэрэглээнд оруулах мэдээллийн нэгдсэн систем бий болгох шаардлагатай байна. Энэхүү систем нь аль нэг байгууллага, хүрээлэнгийн өмчлөлд байх бус, нийтийн зориулалттай, төрийн байгууллагуудын дундын хэрэгцээнд зориулагдсан байх нь зохистой юм.

САНАЛ:

Иймд дараах саналыг оруулж байна. Үүнд:

1. Судалгааны эх үүсвэрүүдийг төвлөрүүлэх, фонд бүрдүүлэх ажлыг ихэвчлэн Парламентын Номын сангууд хариуцан гүйцэтгэдэг. УИХ-ын Номын сан нь Төрийн ордонд байрлаж УИХ, ЗГ, Ерөнхийлөгчийн ажлын албанд үйлчлэхээс гадна Хөгжлийн мэдээллийн төвтэй, Цахим Номын сантай тул мэдээллийн санг төвлөрүүлэх, үйлчилгээ үзүүлэх боломжтой.
2. Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгааны ажлууд, төрийн байгууллагууд болон төрийн өмчит ААН, байгууллагуудын гүйцэтгэсэн судалгааны ажлуудын эх хувийг УИХ-ын Номын санд цахим болон цаасан хэлбэрээр төвлөрүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх
3. ШУА, ШУТС, Үндэсний Номын сан, Шинжлэх ухаан технологийн парк, их, дээд сургуулиуд болон Засгийн газрын судалгааны мэдээллийн санг УИХ-ын мэдээллийн сантай холбох
4. Шийдвэр гаргах түвшинд ажилладаг төрийн институцийн цахим дата сан бүрдүүлэх, мэдээллийн портал сайт ажиллуулах, программ хангамж боловсруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх
5. УИХ-ын Судалгааны албаны статусыг дээшлүүлж, цаашид бие даасан байдлаар ажиллах, төсөв санхүүгийн болон эрх зүйн орчныг бүрдүүлэх
6. Одоогийн нөхцөлд УИХТГ-ын Судалгаа, шинжилгээний хэлтсийн орон тоог нэмэгдүүлэх. Одоогоор Судалгааны албанд 2-3, Номын санд 1-2, Архивт-1 орон тоо зайлшгүй нэмэх шаардлагатай. Ялангуяа Номын сан, Архив нь үйлчилгээний статустай, техник ажиллагаа ихтэй тул зарим чиг үүргийн ажлаа хийж чадахгүй байх, хэт их ачаалалд орох байдал гарч байна.
7. Одоогийн бүтцийн хүрээнд Судалгаа шинжилгээний хэлтсийг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад харьяалуулж, Судалгаа шинжилгээний төв болгон нэршлийг өөрчлөх. “Төв“ гэж нэрлэснээр гадаад, дотоод орчинд зөв ойлгогдох, бусад байгууллагуудтай харилцаа хамтын ажиллагаа сайжрах, үнэлэмж нь дээшлэх боломжтой.
8. СШХ-ийг одоогийн ачааллаар цомхон орон тоотой ажиллуулах тохиолдолд хэвийн ажиллах тодорхой нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай. Тухайлбал, захиргааны ажилд аль болох дайчлахгүй байх, үндсэн ажлаас бусад ажил, үйлчилгээг 1 цонхонд шилжүүлэх, статистик дата сан, судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх, улсын хэмжээний судалгааны ажлуудыг Номын санд төвлөрүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, судалгааны мэдээллийг харьяа байгууллагуудаас гаргуулан авах эрхтэй байх, бусад судалгааны байгууллага, хүрээлэнгүүдтэй шууд харилцах, хамтран ажиллах боломжтой байх, ачаалал ихэссэн үед гэрээт судлаачдыг татаж ажиллуулдаг байх, гадаад, дотоодын судалгааны сан, хуулийн мэдээллийн санд нэвтрэх эрхтэй байх, бусад орнуудын парламентын судалгааны албадтай хамтарч ажиллах, түншлэх, мэргэжил арга зүйн туслалцаа авах боломжтой байх,
9. Судалгааны албанд цаашид өндөр түвшний мэдлэг, ур чадвартай хүн ажиллуулахын тулд ажилтнуудын албан тушаалын ангилал, цалингийн шатлалыг ахиулах,

Судалгаа шинжилгээний хэлтсийн дарга Ц. Норовдондог

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 214 | Улаанбаатар хот

Мэдээллийн нэгдсэн сан байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, зохицуулах журам”-ыг 1 дүгээр хавсралт ёсоор, “Мэдээллийн санд төвлөрүүлэх мэдээлэл, тэдгээрийг гаргах байгууллагын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлалсугай.

2. Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.АЛТАНХУЯГ

Эдийн засгийн хөгжлийн сайд Н.БАТБАЯР

Засгийн газрын 2013 оны 214 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилт нь хөгжлийн бодлого боловсруулах, макро эдийн засгийн төсөөлөл хийх, хөрөнгө оруулалт төлөвлөх ажлын хүрээнд судалгаа, тооцоо хийхэд шаардлагатай мэдээллийн нэгдсэн сан байгуулах, түүнийг зохицуулахад оршино.

Хоёр. Журмын нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Үндэсний эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэдгийг Сангийн сайдын 2011 оны 103 тоот тушаалаар батлалсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын дагуу тухайн оны нийт үйлдвэрлэлд тухайн аж ахуйн нэгжийн ирэх 10 жилд үйлдвэрлэх үйлдвэрлэлийн жилийн дундаж хэмжээ 5 хувиас дээш эзэлж байгаа аж ахуй нэгжийг;

2.1.2. “Маягт” гэдгийг Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлах маягт.

Гурав. Мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлэх мэдээллийн төрөл, хамрах хүрээ

3.1. Мэдээллийн санд мэдээллээ өгөх үүрэг бүхий байгууллагууд:

3.1.1. яам, агентлаг;

3.1.2. орон нутгийн удирдлагын байгууллага;

3.1.3. Шинжлэх ухааны академи, судалгааны хүрээлэнгүүд, төрийн өмчит их, дээд сургууль;

3.1.4. үндэсний эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байгаа болон оруулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж.

3.2. Мэдээллийн санд төвлөрүүлэх мэдээллийн төрөл:

3.2.1. статистик мэдээлэл;

3.2.2. бодлогын судалгаа;

3.2.3. техник, эдийн засгийн үндэслэл;

3.2.4. аж ахуйн нэгжийн санхүүгийн болон маягтын дагуух мэдээлэл;

3.2.5. аж ахуйн нэгжийн маягтын дагуу эдийн засгийн төлөвлөгөө, төсөөлөл.

Дөрөв. Мэдээллийг цуглуулах үе шат

4.1.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталсан маягт, жагсаалтын дагуу мэдээллийг энэхүү журмын 3.1-д заасан байгууллагууд нэгтгэн гаргана.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан мэдээллийг Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим болон цаасаар хүргүүлнэ.

4.3. Энэхүү журмын 4.2-т заасан мэдээллийг ашиглан Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

Тав. Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

5.1. Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1. Монгол Улсын Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах программ хангамжийг бий болгох;

5.1.2. энэхүү журмын 3.2-т заасан мэдээллийн төрлийн хүрээнд дэлгэрэнгүй мэдээллийн жагсаалт болон мэдээлэл авах цахим, бичгийн форматыг батлах;

5.1.3. энэхүү журмын 3.1-д дурдсан байгууллагаас журмын 3.2-т заасан мэдээллийг авч Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан бий болгох;

5.1.4. үндэсний аюулгүй байдал болон хуулийн этгээдийн нууцлалтай холбоотой мэдээллийн нууцлалыг чанд хадгалах;

5.1.5. мэдээллийн нэгдсэн сангийн тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Засгийн газарт танилцуулах.

Зургаа. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

6.1. Энэхүү журмын 3.1-д заасан төрийн байгууллага нь энэ журмын 3.2-т заасан мэдээллийн төрлийн хүрээнд эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын

гишүүний баталсан мэдээллийн жагсаалт, маягтын дагуу мэдээллээ цахим болон албан тоотоор тус байгууллагад хүргүүлнэ.

6.2. Энэхүү журмын 3.1-д заасан төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглана.

Долоо. Шинжлэх ухааны академи, судалгааны хүрээлэн, их, дээд сургуулийн эрх, үүрэг

7.1. Шинжлэх ухааны академи, их дээд сургуулиуд нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа улирал болгоны эхний долоо хоногт багтаан цахим хэлбэрээр эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Найм. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үүрэг

8.1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор дараах мэдээллийг цахим болон албан бичгээр эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

8.1.1. Үндэсний статистикийн хорооны даргын 2003 оны 12 дугаар тушаалаар батлагдсан АҮ-7 маягтын дагуу өмнөх жилийн үйлдвэрлэл, борлуулалт, санхүүгийн тайлан;

8.1.2. Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулсан маягт, загварын дагуу үндсэн үйл ажиллагааны болон эдийн засгийн ирэх таван жилийн зорилт, төлөвлөгөө;

8.1.3. Техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа.

Ес. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын эрх үүрэг

9.1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

9.1.1. Эдийн засгийн хөгжлийн яамнаас жил бүрийн эхний хагаст Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сангийн хэрэгжилтийн талаар тайлан, мэдээллийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байх;

9.1.2. Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сангийн журмын хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.3. Мэдээллийн нэгдсэн сантай холбоотой санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх;

9.1.4. Журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох арга хэмжээг авах санал гаргах.

Засгийн газрын 2013 оны 214 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

д/д	*Мэдээлэл*		*Хугацаа*	*Хариуцан гаргах байгууллага*
1	Макро эдийн засгийн үзүүлэлт	Нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ (түүхий эд, түлш эрчим хүч, усны хэрэглээ гэх мэт), нэмэгдэл өртөг (цалин, татвар гэх мэт)-ийг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дэлгэрэнгүй байдлаар	Улирал, жилээр	ҮСХ
2		Хэрэглээний үнийн индексийн (цаашид ХҮИ гэх) шинэчилсэн сагсанд орсон Улаанбаатар хотын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, тарифын динамик (сар бүр, 2010 оноос хойш)	Сар, улирал, жилээр	ҮСХ
3		ХҮИ-ийн шинэчилсэн сагсанд орсон Улаанбаатар хотын бүтээгдэхүүн, үйлчилгээний хувийн жин	Улирал, жилээр	ҮСХ
4		Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын индексийг шинэ сагсаар тооцохдоо ашигласан суурь оны мэдээлэл	Сар, улирал, жилээр	ҮСХ
5		ДНБ-ий эцсийн ашиглалтын гүйцэтгэлийн задаргаа (1990 оноос хойш)	Улирал, жилээр	ҮСХ
6		Хөрөнгө оруулалт, эх үүсвэрийн ангиллаар (1990 оноос хойш)	Жилээр	ҮСХ
7		Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (задаргаа)	Сар, улирлаар	СЯ
8		Засгийн газрын өрийн хэмжээ (задаргаа)	Улирал, жилээр	СЯ
9		Гадаад валютын цэвэр албан нөөц	Сар, улирал, жилээр	ҮСХ
10		Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт	Улирал, жилээр	ХЯ, ҮСХ
11		Аж ахуйн нэгж, байгууллагын дундаж цалин, салбар тус бүрээр	Улирал, жилээр	ҮСХ
12		Далд эдийн засаг, эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн ангиллаар	Улирал, жилээр	ҮСХ
13		Өрхийн орлого, зарлагын судалгааны задгай тоон мэдээлэл	Улирал, жилээр	ҮСХ
14		Ажиллах хүчний түүвэр судалгааны задгай тоон мэдээлэл	Улирал, жилээр	ҮСХ
15		ISIC ангиллаар гадаад худалдааны бараа бүтээгдэхүүний ангилсан хэмжээ	Сар, улирал, жилээр	ҮСХ
16		Аж ахуйн нэгжийн тоо, түүнд ажиллагсад салбар түс бүрээр (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ҮСХ
17		Малын тоо, төрлөөр (аймаг, сум)	Улирал, жилээр	ҮСХ
18		Малтай өрхийн тоо, малчдын тоо (аймаг, сум)	Улирал, жилээр	ҮСХ
19		Хээлтэгч малын тоо, төл малын тоо (аймаг, сум)	Улирал, жилээр	ҮСХ

20	Нийгмийн салбарын үзүүлэлт	Суурин хүн амын тоо, хот, хөдөөгөөр (аймаг, сум, дүүрэг, хороо)	Сар, улирал, жилээр	ҮСХ
21		Суурин хүн амын тоо, хүйсийн харьцаагаар (аймаг, сум, дүүрэг, хороо)	Сар, улирал, жилээр	ҮСХ
22		Суурин хүн амын тоо, насны бүлгээр (аймаг, сум, дүүрэг, хороо)	Сар, улирал, жилээр	ҮСХ
23		Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ҮСХ
24		Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдийн тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ҮСХ
25		Өрхийн тоо, ам бүлээр (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ҮСХ
26		Хүн амын шилжилт хөдөлгөөн (аймаг, сум)	Улирал, жилээр	ҮСХ
27		Хүн амын төрөлт, нас баралт, ердийн өсөлт (сум, хороо)	Улирал, жилээр	ҮСХ
28		Хүн амын өвчлөлт төрлөөр (сум, хороо)	Улирал, жилээр	ҮСХ
29		Ядуурлын түвшин (аймаг, дүүрэг)	Жилээр	ХАХНХЯ, ҮСХ
30		Ажилгүйдлийн түвшин (аймаг, дүүрэг)	улирал, жилээр	ҮСХ
31	Боловсролын салбарын үзүүлэлт	Цэцэрлэгийн суудлын тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
32		Цэцэрлэгийн хамран сургалтын индекс (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	
33		Ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
34		Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	
35		Дотуур байрны орны тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
36		Дотуур байранд хамрагдалтын индекс (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	
37		Нэмж барих шаардлагатай цэцэрлэгийн суудлын тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
38		Нэмж барих шаардлагатай сургуулийн суудлын тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
39		Нэмж барих шаардлагатай дотуур байрны орны тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
40		Ерөнхий боловсролын сургуулийн эзлжийн коэффициент (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
41		Цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангалтын индекс (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
42		Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалтын индекс (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БШУЯ, ҮСХ
43		Мэргэжлийн боловсролын сургууль төгсөгчдийн ажлын байрны хангалт (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	ХЯ, ҮСХ
44		Боловсролын салбарт хийгдэж байгаа бодлогын судалгаа, ТЭЗҮ	Жилээр	БШУЯ
45		Эрдэм шинжилгээний судалгаа	Улирал, жилээр	БШУЯ, ШУ-ны хүрээлэн, төрийн өмчит их, дээд сургууль,

46	Эрүүл мэндийн салбарын үзүүлэлт	100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭМЯ, УСХ
47		1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭМЯ, УСХ
48		1000 амьд төрөлтөд ногдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭМЯ, УСХ
49		100000 хүн амд ногдох сүрьеэ өвчнөөс шалтгаалсан нас баралт (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭМЯ, УСХ
50		10000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭМЯ, УСХ
51		10000 хүн амд ногдох эмнэлгийн салбарт ажиллагсдын тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭМЯ, УСХ
52		10000 хүн амд ногдох урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагсдын тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭМЯ, УСХ
53		Эрүүл мэндийн салбарт хийгдэж буй бодлогын судалгаа, ТЭЗҮ	Жилээр	ЭМЯ
54	Хүрээлэн буй байгаль орчин	Агаарын бохирдлын хэмжээ (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БОНХЯ, УСХ
55		Усны бохирдлын хэмжээ (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БОНХЯ, УСХ
56		Цөлжилтийн хувь (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БОНХЯ, УСХ
57		Уул уурхайн газрын нөхөн сэргээлтийн хувь (аймаг, сум, дүүрэг, хороо)	Жилээр	БОНХЯ, УСХ
58		Байгаль орчны салбарт хийгдэж байгаа бодлогын судалгаа болон ТЭЗҮ	Жилээр	БОНХЯ
59	Соёл, урлаг, спорт, аялал жуулчлалын салбар	Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт, үзэгчдийн тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
60		Музейн үзмэр, үзэгчдийн тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
61		Нийтийн номын сан, байнгын уншигчдын тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
62		Соёлын төвийн зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдагсдын тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
63		Кино үзвэрийн цэг, үзэгчдийн тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
64		Соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
65		Соёл, урлагийн байгууллагын ажилчдын тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
66		Нийт ажиллагсдын тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
67		Спортоор хичээллэгсдийн тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
68		Цол, зэрэгтэй тамирчин, дасгалжуулагч	Жилээр	ССАЖЯ, УСХ
69		Цол, зэрэгтэй шүүгч	Жилээр	ССАЖЯ, УСХ
70		Зохион байгуулсан ажил үйлчилгээ	Жилээр	ССАЖЯ, УСХ
71		Жуулчдын тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ, ХХЕГ
72		Жуулчин хүлээн авах хүчин чадал, даац	Жилээр	ССАЖЯ, УСХ
73		Салбарын ажиллагсдын тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ
74		Нийслэлийн зочид буудлуудын нийт ор	Жилээр	ССАЖЯ, УСХ
75		Салбарын орлого	Жилээр	ССАЖЯ, УСХ
76		Тухайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын тоо	Жилээр	ССАЖЯ, УСХ, УБЕГ
77	Дэд бүтцийн хангамж	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭХЯ, УСХ
78		Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл аж ахуйн нэгжээр (аймаг)	Улирал, жилээр	ЭХЯ, УСХ
79		Дулаан хангамжийн системд холбогдсон өрхийн тоо (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭХЯ, УСХ
80		Тухайн орон нутгийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны тоо, айлын тоогоор (аймаг, сум, дүүрэг, хороо)	Улирал, жилээр	ЭХЯ, УСХ
81		Тухайн онд ашиглалтад орсон хатуу хучилттай замын урт (аймаг, дүүрэг)	Улирал, жилээр	ЗТЯ, УСХ

82	Уул уурхайн салбарын үзүүлэлт	Эрдэс бүтээгдэхүүний олборлолтын хэмжээ (нүүрс, зэс, алт, мөнгө гэх мэт), Эрдэс баялгийн экспорт	Жил, улирлаар, төлөвлөгөө	Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар, төрийн өмчийн болон үндэсний томоохон аж ахуйн нэгжүүд
83		Бензин, дизелийн түлшний хилийн үнэ	Сараар	Газрын тосны газар
84		Уул уурхайн нөхөн сэргээлтийн хувь (аймаг, сум, дүүрэг)	Жилээр	УУЯ, БОНХЯ
85	Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үзүүлэлт	Газар тариалангийн салбарын үйлдвэрлэл, хэтийн тооцоо, төсөөлөл (аймаг)	Улирал, жилээр	ҮХААЯ, ҮСХ
86		Ноолуурын салбарын үйлдвэрлэл, аж ахуйн нэгж (аймаг)	Улирал, жилээр	ҮХААЯ, ҮСХ
87		Нэхмэлийн салбарын үйлдвэрлэл (аймаг)	Улирал, жилээр	ҮХААЯ, ҮСХ
88		Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, аж ахуйн нэгж (аймаг)	Улирал, жилээр	ҮХААЯ, ҮСХ
89		Барилгын материалын үйлдвэрлэл (аймаг)	Улирал, жилээр	ҮХААЯ, ҮСХ
90		Хөдөө аж ахуйн биржийн үзүүлэлтүүд	Улирал, жилээр	ҮХААЯ
91		Мах, сүүний чиглэлийн фермийн нарийвчилсан мэдээлэл	Жилээр	ҮХААЯ
92	Байгаль орчны салбар	Монгол орны уур амьсгал түүний өөрчлөлтийн талаарх мэдээлэл	Жилээр	БОНХЯ
93	Бусад	Хөрөнгө оруулалтын хэмжээ, тэрбум төгрөг, эх үүсвэр болон технологийн төрөл.	Жил, улирлын гүйцэтгэл болон төлөвлөгөө	ҮСХ, төрийн өмчийн болон үндэсний томоохон аж ахуйн нэгжүүд, ЭЗХЯ
		Үл хөдлөх хөрөнгийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл	Сар, улирал, жилээр	УБЕГ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 06 сарын 07 өдөр Дугаар 187 Улаанбаатар хот

Дүрэм, журам батлах тухай

Боловсролын тухай хуулийн 28.1.2 дугаар заалт, Дээд боловсролын тухай хуулийн 8.8, 8.10 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.”Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”-ыг нэгдүгээр, “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийг хоёрдугаар, “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан журам, дүрмийг 2007 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.

3.Батлагдсан журамд нийцүүлэн сургуулийнхаа хэмжээнд мөрдөх магистрын болон докторын сургалтын журмыг 2007 оны 7 дугаар сарын 1-ний дотор боловсруулан батлах арга хэмжээ авахыг магистр, докторын сургалт эрхэлдэг их сургууль, дээд сургуулийн захирал нарт даалгасугай.

4.Энэхүү тушаалыг хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар (Р.Бат-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 348 дүгээр тушаалаар баталсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”, 2000 оны 110 дугаар тушаалаар баталсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”, “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийг тус тус 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хүчингүй болгосугай.

САЙД Ө.ЭНХТҮВШИН

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны
187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТ ЭРХЛЭХЭД БАРИМТЛАХНИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Журмын зорилт

1.1.Энэхүү нийтлэг журмын зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургууль” гэнэ)-д дээд боловсролын магистр, докторын сургалт эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Сургуулийн хэмжээнд баримтлах магистр, докторын сургалтын журам (цаашид “сургалтын журам” гэнэ)-ыг энэхүү журамд нийцүүлэн тухайн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, сургуулийн захирал батална.

2.Сургалтын агуулга

2.1.Магистр, докторын боловсролын агуулга нь суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээнд мэргэжлийн өндөр төвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэнэ.

3.Сургалт эрхлэх эрх

3.1.Зохих нөхцөлийг хангасан сургууль нь магистр, докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай» болон “Боловсролын тухай” хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна.

3.2.Магистр, докторын сургалт эрхлэх сургууль нь тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил суурь болон хавсарга судалгаа шинжилгээний ажлыг өөрийн мэргэшсэн, туршлагатай багш нарын хүчээр тасралтгүй явуулж үр дүнд хүрсэн, энэхүү судалгааны ажилд зохих хөрөнгө төсөвтөө тусган зарцуулдаг байна.

3.3.Сургууль нь магистр, докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахаас өмнө магистрант, докторант элсүүлэх тухай нийтэд зарлах, сурталчлах, элсүүлэхээр тохиролцох, элсэлт авахыг хориглоно.

Хоёр. Сургалтын орчны шаардлага

4.Удирдлага

4.1.Магистр, докторын сургалт эрхэлдэг сургууль нь энэ төвшний сургалтын ажил хариуцсан удирдлагын нэгжтэй байна. Энэхүү нэгжийн дарга (захирал, эрхлэгч)-нь удирдах ажил буюу багшлах ажлын 3-аас доошгүй жилийн туршлагатай, судалгаа шинжилгээний ажил хийдэг, докторын зэрэгтэй хүн байна.

4.1.1. Энэхүү журмын 4.1.-д дурдсан нэгж нь сургуулийн хэмжээний магистр, докторын сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, магистр, докторын зэрэг хамгаалах зөвлөл байгуулах ажлыг зохион байгуулах, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх үүрэгтэй.

4.2.Сургууль нь магистр, докторын зэргийн сургалтад хичээл заадаг багш нарт тухайн төвшний сургалтын онцлог, хөдөлмөр зарцуулалт болон тэдний мэргэжлийн ур чадварт дүйцсэн цалин хөлс олгоно.

4.3.Сургууль нь багш нараар судалгаа шинжилгээний ажил эрхлэх боломж, нөхцөл бүрдүүлнэ.

4.4.Магистр докторын сургалтыг тухайн сургуулийн мэргэжлийн тэнхим буюу профессорын баг хариуцаж зохион байгуулна.

5.Багш

5.1.Магистрын сургалтад мэргэжлийн хичээл заадаг багш, докторын сургалтад хичээл заадаг багш нь бүгд тухайн чиглэлээр докторын зэрэгтэй байх шаардлагатай.

5.2.Магистр, докторын сургалтад оролцдог бүх багш судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг байх ёстой.

6.Магистрант, докторантын удирдагч

6.1.Сургалтын байгууллага магистрант, докторантын элссэн улиралд багтаан суралцагч нэг бүрээр эрдэм шинжилгээний ажлын удирдагч (Цаашид “удирдагч” гэнэ) томилно.

6.1.1.Докторын ажил (Цаашид “диссертац” гэнэ)-ын сэдвийн онцлогийг харгалзан хамтарсан удирдагч томилж болно.

6.1.2. Гадны байгууллагын судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг ажилтныг удирдагчаар томилж болно. Энэ тохиолдолд тухайн салбар, чиглэлээр удирдагчаар томилж болно. Энэ тохиолдолд тухайн салбар, чиглэлийн удирдагчаар ажиллуулах үндсэн багш ба гадны байгууллагын хүмүүсийн тооны харьцаа 2-оос багагүй байна. */БСШУСайдын 2007 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 459 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон/*

6.2.Удирдагч нь магистрын ажил, диссертацын сэдэв тодорхойлох, суралцагчийн судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулах, судалгааны ажил хийх болон магистрын ажил, диссертац бичих явцад тодорхой хуваариар мэргэжлийн зөвлөгөө өгч, хяналт тавих, ажлын агуулгыг хэсэг бүрээр болон бүхэлд нь дүгнэх, удирдсан магистрын ажил, диссертацыг хамгаалалтад оруулах зөвшөөрөл өгөх, эрдэм шинжилгээний болон судалгааны семинар зохион байгуулж суралцагч уг семинарт судалгааны ажлынхаа үр дүнг илтгэн хэлэлцүүлж байх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

6.3.Магистрын ажлын удирдагч нь докторын зэрэгтэй, тухайн чиглэлээр 5-аас цөөнгүй жил дээд боловсролын байгууллагад багшилсан буюу эрдэм шинжилгээний ажил эрхэлсэн, сүүлийн 5 жилд 3-аас цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж мэргэжлийн үнэлгээнд үндэслэн шилж сонгож хэвлэдэг (рецензбүхий) мэргэжлийн хэвлэлд хэвлүүлсэн, докторын ажлын удирдагч нь энэ шаардлагаас гадна мөн тухайн чиглэлээр сүүлийн 3 жилд 1-ээс цөөнгүй ганц сэдэвт зохиол буюу эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн байвал зохино.

6.4.Удирдагч томилох, нэг багшийн удирдах магистрант, докторантын тоог тогтоох асуудлыг тухайн сургуулийн сургалтын журамд заавал тусгана. Магистрын ажил, диссертац удирдах нь багшийн ажлын үндсэн ачаалалд тооцогдоно.

7.Номын сан, мэдээллийн бааз

7.1.Сургуулийн номын сан нь магистр, докторын сургалт явуулж буй чиглэлүүдээр мэргэжлийн сэтгүүл захиалдаг, интернетэд холбогдсон, магистр, докторын сургалтын чиглэл бүрд хүрэлцэхүйц хэмжээний ном, сурах бичигтэй байхаас гадна мэргэжлийн сэтгүүл, ном зүйн лавлагаа, нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний цувралын сантай байх ёстой.

7.2.Номын сангийн чанарыг уншигчдад хүргэх мэдээллийн цар хүрээ, уг мэдээллийн шинжлэх ухааны төвшин, шинжлэх ухааны олон салбарыг төлөөлж чадахуйц эх сурвалж болж буй байдал, ном хэвлэлийн шинэлэг байдал зэрэг хүчин зүйлээр тодорхойлно.

7.3.Номын сан нь магистрант, докторантад зориулсан уншлагын танхимтай байх ёстой.

7.4.Сургууль нь магистрант, докторантыг интернет байнга ашиглах боломжоор хангана.

7.5.Сургуулиуд жилд 1-ээс доошгүй удаа хэвлэдэг өөрийн эрдэм шинжилгээний сэтгүүлтэй байна.

Гурав. Сургалтын үйл ажиллагаа

8.Магистрант, докторант элсүүлэх

8.1.Магистрантурт элсэх хүн бакалаврын, докторантурт элсэх хүн магистрын зэрэгтэй байна.

8.1.1.Иргэн өмнө эзэмшсэнээс өөр чиглэлээр дараагийн шатны магистрын зэргийн сургалтад хамрагдах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах зөрүү гарсан хичээлийг нөхөн үзнэ. Ийнхүү үзсэн хичээлийг магистрын зэрэг олгох үндсэн хичээлд хамааруулахгүй.

8.1.2.Иргэн өмнө эзэмшсэн магистрын зэрэг хамгаалсан чиглэлээс өөр чиглэлээр дараагийн шатны докторын зэргийн сургалтад хамрагдах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах зөрүү гарсан хичээлийг нөхөн үзнэ. Ийнхүү үзсэн хичээлийг докторын зэрэг олгох үндсэн хичээлд хамааруулахгүй.

8.2.Сургууль нь магистр, докторын боловсрол эзэмших хүмүүсийг элсүүлэхэд тавих шаардлагыг сургуулийн дүрэм эсхүл сургалтын журамдаа тодорхой тусгана. Сургууль нь элсэгчдийн өмнө нь эзэмшсэн боловсрол болон бусад шаардлагыг тусгасан тусгай нөхцөл тавьж болно. Магистрант, докторант элсүүлэх ажил нь тухайн төвшний сургалтад амжилттай суралцаж чадах хүмүүсийг сонгон шалгаруулж элсүүлэх уралдаант шалгалт байна.

8.3.Ижил чиглэлээр сонгон шалгаруулах шалгалтыг холбогдох сургуулиуд хамтран зохион байгуулж болно. Шалгаруулалтын нэг хэсэг болгон төвшин тогтоох шалгалтыг үнэлгээний ажлаар мэргэшсэн хөндлөнгийн байгууллагаар төвлөрсөн байдлаар зохион байгуулж болно.

8.4**.** Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага элсэгчдийн тоог холбогдох сургуулийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, саналыг үндэслэн тогтооно.

8.5.Магистрант, докторантыг сургалт эрхлэх зөвшөөрөл авсан хөтөлбөрөөр сургахаар элсүүлнэ.

8.6.Гадаадын суралцагч монгол хэлээр сургалтад хамрагдах шаардлагыг хангасан байна. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу суралцуулахад хэлэлцээрт заасан нөхцөлийг баримтална.

8.7.Магистрант, докторантаар суралцуулах тухай захирлын тушаал гарснаар иргэнийг тухайн сургууль элссэнд тооцно. Тушаалд сургалтын чиглэл, сургах хэлбэрийг тодорхой заасан байна.

8.8**.**Магистрант, докторант элсүүлэх ажлыг хичээлийн улирал эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө дуусгасан байхаар зохион байгуулна.

9.Суралцагчийг бүртгэх, шилжилт хөдөлгөөн

9.1.Суралцагчийг бүртгэх, чөлөө олгох, сургуулиас хасах, чөлөөлөх, шилжиж ирсэн суралцагчийн хувьд дүйцүүлэн тооцож болох багц цагийн дээд хэмжээ, үргэлжлүүлэн сургах асуудлыг сургуулийн сургалтын журамд нарийвчлан тусгана. Шилжин ирсэн суралцагчийн бусад сургууль судалсан хичээлээс дүйцүүлэн тооцож болох багц цагийн хэмжээ магистрантурын тухайд 10, докторантурын тухайд 20 багц цагаас ихгүй байна. */ БСШУСайдын 2007 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 459 дүгээр тушаалаар өөрчлөлт орсон/*

10.Хичээлийн жил, улирал, сургалтын хугацаа

10.1.Магистр, докторын сургалтын хичээлийн жил 15-аас доошгүй долоо хоног бүхий хоёр улирлаас тогтоно.

10.2.Өдрийн хэлбэрээр суралцагч (бүрэн ачаалалтай суралцагч)-ийн нэг улирлын ачаалал 9-12 багц цаг байна.

10.3.Өдрийн бус хэлбэрээр суралцагчийн нэг улирлын ачаалал нэг улиралд 6-багц цагаас ихгүй байна.

10.4.Тэнхимийн зөвшөөрлийг үндэслэн суралцагч авъяас чадвар, бэлтгэлээсээ хамааруулан нэг улиралд 3 хүртэл багц цагийн хичээл нэмж үзэж болно.

10.5.Магистр, докторын сургалтын норматив хугацааг сургуулийн сургалтын журамд тусгана. Магистрын ажил, диссертацаа судалгааны ажлын төлөвлөгөөнд заасан норматив хугацаанд гүйцэтгэж өргөн бариагүй буюу магистрын ажил, диссертацаа хамгаалж чадаагүй суралцагчийн суралцах хугацааг 2 хүртэл жилээр сунгаж болно. Ийнхүү сунгасан хугацаанд сургалтаа дүүргээгүй суралцагчийг сургуулиас хасна.

11.Мэдлэг, чадварыг дүгнэх

11.1.Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэхдээ A, B, C, D, F гэсэн үсгэн дүн, 4, 3, 2, 1, 0 гэсэн тоон дүн болон процентон дүн хэрэглэнэ. Үсгэн, процентон болон тоо (оноо)-н дүнгүүдийг дараах жишгээр нэгээс нөгөөд шилжүүлнэ.

11.2.Сургууль суралцагчийг зарим хичээлд C буюу түүнээс дээш дүн авсан байх шаардлага тавьж болно.

12.Агуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр

12.1.Дээд боловсрол эзэмшүүлэх магистрын сургалт 30, докторын сургалт 60 багц цагаас тус тус доошгүй байна.

12.2.Магистр, докторын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургалтын байгууллагын захирал өөрийн сургууль дээр мөрдөх магистр, докторын үлгэрчилсэн сургалтын төлөвлөгөөг сургалтын чиглэл бүрээр Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн батална.

12.3.Энэхүү дүрмийн 12.2-д дурдсан үлгэрчилсэн сургалтын төлөвлөгөөг үндэслэн суралцагч бүр удирдагчтайгаа зөвшилцөн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулна. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах, батлах, өөрчлөлт оруулах асуудлыг сургуулийн сургалтын журамд тусгана.

12.4.Сургалтын төлөвлөгөөн дэх хичээл бүрийн хөтөлбөр нь уг хичээлийн зорилго, багтаамж, судлагдахуун, ашиглах сурах бичиг, ном зохиол, лавлах зэргийг заавал багтаасан байна.

12.5.Магистрантурын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүд судалгааны арга зүй, англи хэл, мэргэжлийн болон мэргэших хичээл, магистрын ажил гэсэн бүтэцтэй байна. Мэргэших хичээл 15 багц цагаас багагүй, магистрын ажил 6 багц цагийн багтаамжтай байна.

12.6.Докторын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүд эрдэм шинжилгээний арга зүй, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл, эрдэм шинжилгээний ажил, диссертац гэсэн бүтэцтэй байна. Эрдэм шинжилгээний арга зүйн хичээл нь сургалтын чиглэлийн онцлогоос хамаарч нэг буюу хэд хэдэн хичээлээс бүрдэх бөгөөд агуулгад нь тоон болон чанарын судалгааны арга зүйн асуудлуудыг тусгана. Мэргэшүүлэх хичээл нь докторантын сургалтын нарийн чиглэл, диссертацын судалгааны чиглэлд хамаатай байх бөгөөд нийтдээ 30 багц цагаас багагүй байна. Эрдэм шинжилгээний ажил нь докторант сонгосон

сэдвийнхээ чиглэлээр удирдагчийн удирдлагын дор зохион байгуулалттай, системтэй, батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж буй судалгааны ажил байх бөгөөд нийт багтаамж нь 6 хүртэл багц цаг байна. Диссертац 12 багц цагийн багтаамжтай байна.

13.Гадаад хэлний болон нэгдсэн шалгалт

13.1.Магистрант нийт судлах хичээлийн 2/3-ыг үзсэний дараа гадаад хэлний шалгалт өгнө. Энэ шалгалтыг гурваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулна.

13.2.Докторант хичээлээр авах багц цагийг гүйцээсний дараа гадаад хэлний болон мэргэжил, мэргэших чиглэлээрх мэдлэг, диссертац бичихэд шаардлагатай бие даасан судалгаа явуулах чадварыг нотлох зорилго бүхий нэгдсэн шалгалтыг тус тус өгнө. Эдгээр шалгалтыг гурваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулна.

13.3.Гадаад хэлний болон нэгдсэн шалгалт авах журмыг сургуулийн сургалтын журамд тусгана.

13.4.Гадаад хэлний шалгалтад хангалттай дүн авч чадаагүй (Тухайн сургуулийн шаардлагыг хангаагүй) суралцагч гадаад хэлний зохих сургалтад хамрагдан дахин шалгалт өгнө. Энэхүү сургалтын хугацаа болон багтаамж сургалтын норматив хугацаа, багтаамжид тооцогдохгүй.

14.Сэдэв, судалгааны ажлын төлөвлөгөө

14.1.Магистрант нийт судлах хичээлийн 2/3-ыг үзсэний дараа магистрын ажлын сэдэв, судалгаа хийх төлөвлөгөөг тус тус батлуулна.

14.2.Докторант энэхүү журмын 13.2-д заасан шалгалтуудыг өгсний дараа диссертацын сэдэв, судалгаа хийх төлөвлөгөөг тус тус батлуулна. Судалгааны ажлын төлөвлөгөө нь зорилго, энэ зорилгыг тодорхойлох хүртэл хийсэн онолын судалгааны тойм, судалгааны арга, суралцагчийн хийх судалгааны төлөвлөгөөг багтаасан байна.

14.3.Магистрын ажил, диссертацын сэдэв, судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах процедур, суралцагчийн судалгааны ажлын төлөвлөгөө, магистрын ажил, диссертацид тавих сургуулийн хэмжээний нийтлэг шаардлагыг сургуулийн сургалтын журамд тусгана.

14.4.Докторант судалгааны ажлын төлөвлөгөөгөө Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 187 дугаар тушаалаар батлсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийн 3.3-д заасан Зөвлөх комиссын хуралдаанаар заавал хэлэлцүүлнэ.

15.Магистрын ажил

15.1.Магистрын ажлыг Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална. Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрмийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

15.2.Магистрын ажлыг тухайн сургуулиас баталсан загвар, шаардлагын дагуу бичнэ.

15.3.Магистрын ажилд судалгааны шинэ үр дүнг тусгана. Магистрын ажлын судалгааг (диссертацын ажлын нэгэн адилаар) системтэй, шинжлэх ухааны аргаар явуулна.

15.4.Магистрын ажлыг хамгаалалтад хамгаалалтад оруулах зөвшөөрөл өгөх журмыг сургуулийн сургалтын журамд тусгана.

16.Диссертац

16.1.Диссертацыг Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална. Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрмийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

16.2.Диссертацид дараахь шаардлага тавина:

16.2.1.харгалзах салбарын мэдлэгт холбогдол бүхий зорилтыг шийдсэн эсхүл улс орны нийгэм, эдийн засагт холбогдолтой практик асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй (арга, аргачлалын дагуу нотлон)-гээр шийдсэн байх;

16.2.2.горилогч дэвшүүлж буй шинэ шийдлийн үндэслэлээ нарийвчлан нотолсон, урьд өмнө хийгдсэн мэдэгдэж буй бусад шийдлүүдтэй харьцуулж, шүүмжлэлтэйгээр шинэлэг талыг нээн харуулсан байх;

16.2.3.зохих загвар шаардлагыг баримталсан, дотоод нэгдэлтэй, шинжлэх ухааны судалгааны хэлний хэм хэмжээний дагуу бичсэн байх.

16.3.Диссертацыг монгол хэлээр бичнэ. Диссертацын тухай товч танилцуулгыг англи хэл дээр 3 хуудаст багтаан бичиж, диссертацын эцэст хавсаргана.

16.4.Горилогчийн хүсэлт, Докторын зэрэг хамгаалуулах Зөвлөлийн бүрэлдэхүүний дийлэнх олонхын зөвшөөрснөөр диссертацыг ажлыг англи хэл дээр бичүүлж, хамгаалалтыг англи хэл дээр явуулж болно.

16.5.Диссертацыг хамгаалалтад оруулах зөвшөөрөл олгох журмыг сургалтын журамд тусгана.

17.Магистрын ажил, диссертацид иш татахад тавих шаардлага

17.1.Горилогч Магистрын ажил, диссертацид ашигласан материал буюу тодорхой үр дүнгийн зохиогч ба эх сурвалжийг заавал иш татна. Энэхүү иш татах шаардлага нь өөрөө дангаар болон бусадтай хамтран хийсэн эрдэм шинжилгээний ажлын хувьд ч мөн хамаарна.

7.2. Магистрын ажил, диссертацын ном зүй гэсэн хэсэгт зөвхөн уг ажилд иш татсан бүтээлүүдийг тусгана.

18.Судалгааны үр дүнг хэвлүүлэх

18.1.Докторант судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн өөрийн судалгааны ажлын үр дүнгийн талаар тухайн чиглэлийн дотоодын мэргэжлийн үнэлгээнд үндэслэн шилж сонгон хэвлэдэг мэргэжлийн эрдэм шинжилгээний бие даасан сэтгүүлүүдэд 2-оос доошгүй өгүүлэл заавал хэвлүүлсэн байна. Тухайн сургууль гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл бичиж хэвлүүлэх шаардлага тавьж болно.

18.2.Энэхүү журмын 18.1-д заасан шаардлагыг докторант хангаагүй бол диссертацыг Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэхгүй.

19.Магистрын ажил, диссертац тушаах

19.1.Зохих шаардлагыг ханган бүрэн эцэслэсэн магистрын ажил, диссертацын 2-оос доошгүй хувь дээр удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурна. Эцэслэсэн магистрын ажил, диссертацыг хэдэн хувь бэлтгэж тушаахыг сургуулийн сургалтын журамд тусгана. Зохиогч диссертацынхаа хувийг Үндэсний номын сан, Мэдээллийн технологийн үндэсний парк, түшиглэсэн болон суралцагчийн суралцсан сургуулийн номын санд, магистрын ажлын хувийг тухайн сургуулийн номын санд заавал хүлээлгэн өгнө.

19.2.Сургууль магистрын ажил, диссертацыг электрон хэлбэрээр авч болно.

20.Магистр, докторын зэрэг олгох шийдвэр гаргах

20.1.Сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн, сургуулиас тогтоосон голч дүнгийн шаардлага хангасан, магистрын ажил, диссертацаа амжилттай хамгаалсан, магистрын ажил, диссертацаа хянан засварлаж эцэслэн холбогдох этгээдэд тушаасан болон сургуулийн бусад шаардлагыг хангасан магистрант, докторантад захирлын тушаалаар магистр, докторын зэрэг олгохоор шийдвэрлэнэ.

* * *

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САН, ШУА-ЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ТУХАЙ

Шинжлэх Ухаан, Технологийн Сангийн Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын мэдээллийн нэгдсэн сан[199]

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын нэгдсэн сан 1975 оноос хойш Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн 3600 гаруй судалгаа боловсруулалтын ажлын тайлан, Эрдэмтдийн Ph.D болон Sc.D-ын зэрэг хамгаалсан 4800 орчим диссертаци, автореферат, 4300 гаруй эрдэмтний нэгдсэн бүртгэл мэдээлэл, Монгол Улсад оновчтой саналын гэрчилгээ авсан бүтээл хадгалагдаж байна. 1995 оноос хойш “Оновчтой санал”-ын гэрчилгээний бүртгэл “Оюуны өмчийн газар”-т албан ёсоор шилжсэн тул нэмж мэдээллийн сан бүрдүүлэх боломжгүй болсон болно.

Оюуны сан дахь мэдээллүүдийн тоог схемээр харуулбал /2013.04.04 -ны байдлаар/:



Эдгээр мэдээллийн эх сурвалжуудыг ашиглан

1.Байгаль,
2.Техник,
3.Анагаах,
4.Хөдөө аж ахуй,
5.Нийгэм хүмүүнлэг гэсэн шинжлэх ухааны 5 салбараар төрөлжсөн “Диссертацийн бүртгэлийн сан”, “Эрдэм шинжилгээний ажлын тайлан”, “Оновчтой санал” нэртэйгээр гурван төрлийн дижитал мэдээллийн санг бүрдүүлэн үйлчилдэг.

“Диссертацийн бүртгэлийн сан” -гийн мэдээллийн үндсэн эх сурвалж нь тухайн эрдэмтний бөглөсөн “Эрдэмтэн” судалгааны асуулга ба эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл байдаг.

“Эрдэм шинжилгээний ажлын тайлан” мэдээллийн сан нь 1975 оноос хойш Монгол улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжсэн эрдэм шинжилгээний бүх төсөлд ажлын тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл ба тайланг бүрэн эхээр нь агуулах зорилготой бөгөөд мэдээллийн эх сурвалж нь уг төсөл хэрэгжиж дуусаад “Итгэмжлэн хадгалагч”-д хүлээлгэн өгсөн эрдэм шинжилгээний төсөлд ажлын тайлан байдаг.

“Оновчтой санал”-ын санд 1961-1995 он хүртэлх хугацаанд Монгол улсад оновчтой саналын гэрчилгээ авсан бүтээлүүдийн тухай мэдээлэл, түүнийг бүрэн эхээр нь агуулах зорилготой бөгөөд мэдээллийн эх сурвалж нь мэдээллийн танхимд хадгалагдаж буй оновчтой саналууд байдаг.

[199]Шинжлэх Ухаан Технологийн сан. http://www.stf.mn/index.php?lang=mn

Дотоодын эрдэмтдийн мэдээллийг электрон хэлбэрээр ашиглахаас гадна олон улсад нэр хүндтэй

- JSTOR,
- OARE,
- AGORA,
- HINARI зэрэг гадаадын эрдэм шинжилгээний электрон сангуудыг ашиглах эрхийг авч эрдэмтэн, судлаачдад үйлчилдэг. Хэрэглэгчийн нэр, нууц үгийг ШУТС-ийн Мэдээллийн танхимаас авч ашиглаж боломжтой.

AGORA
Access to Global Online Research in Agriculture (AGORA) хөтөлбөр нь үнэгүй болон хөнгөвчилсөн төлбөртэйгээр хөдөө аж ахуй болон биологи, байгаль орчин, хүнсний технологи, нийгмийн шинжлэх ухааны дэлхийн нэр хүнд бүхий хэвлэлийн байгууллагуудын 1200 гаруй сэтгүүл ашиглах боломжийг 2003 оноос эхлэн хөгжиж буй орнуудад зориулан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн тусламжтайгаар бодлого боловсруулагчид, судлаачид, техникийн ажилтнууд, оюутнуудад ашиглах боломжийг олгодог.
http://www.aginternetwork.org/en

OARE
Online Access to Research in the Environment (OARE) нь НҮБ-ийн Байгаль Орчны Хөтөлбөр, АНУ-ийн Ийлийн Их Сургууль, Дэлхийн тэргүүлэх шинжлэх ухаан, технологийн хэвлэлийн байгууллагуудын хөгжиж буй орнууд дэлхийн хамгийн том байгаль орчны шинжлэх ухааны судалгааны цуглуулгыг ашиглах бололцоотой олон улсын хамтарсан консорциум юм. 340 орчим нэр хүндтэй хэвлэлийн байгууллагууд, эрдэм шинжилгээний нийгэмлэгүүдийн 2990 гаруй сэтгүүлүүдийг 107 гаруй бага орлоготой орнууд хэрэглэх боломжтой. Биологи, Биотехнологи, Генетик, Ургамал судлал, Цаг уур, цаг уурын өөрчлөлт, Экологи, Сэргээгдэх эрчим хүч, Хүлэмжийн хий, Байгаль орчин, Байгалийн нөөцийн эдийн засаг, Байгаль орчны хууль, бодлого, төлөвлөлт, Газарзүй, Геологи, Хөрс судлал, Тандан судалгаа, Газарзүйн мэдээллийн систем зэрэг судалгаа шинжилгээний өргөн салбаруудын мэдээллүүдийг хамарсан. http://www.oaresciences.org

HINARI
